



ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ
ҮҮСГЭН БАЙГУУЛАГЧИЙН ТӨЛӨӨЛӨГЧ ТОМИЛОХ ТУХАЙ

2005 оны 10 дугаар сарын 13-ны өдөр Дархан

Дугаар 81

Монгол улсын Боловсролын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 3, 36 дугаар зүйлийн 2, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 4 дүгээр заалтуудыг үндэслэн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ: 1.

Аймгийн орон нутгийн өмчийн сургууль, цэцэрлэгүүдийн зөвлөлд аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын бүрэн эрхийн хугацаанд ажиллах үүсгэн байгуулагчийн Төлөөлөгчдийг хавсралтаар баталсугай.

2. Боловсролын тухай хууль тогтоомжид тусгагдсан боловсролын байгууллагуудын зөвлөл болон удирдах зөвлөлийн чиг үүргийг бүрэн хэрэгжүүлж, хагас жил тутамд аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдэд танилцуулж ажиллахыг үүсгэн байгуулагчийн Төлөөлөгч нарт даалгасугай.

3. Энэ тогтол гарсантай холбогдуулан аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2002 оны 96 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА

Л.ГҮНЧИН



БИЧГИЙН

НАРИЙН

Р.ТУНГАЛАГ-ЭРДЭНЭ

ДАРГА